

ТАНИЛЦУУЛГА

2019 оны 01 дүгээр
сарын 18-ны өдөр

Улаанбаатар
хот

ГХЯ-ны 2018 оны үйл ажиллагааны
төлөвлөгөөний биелэлтийн дүнгийн
тухай

Гадаад харилцааны яамны 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу үнэлж, биелэлтийг дүгнэв.

ГХЯ-ны 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд 227 ажил арга, хэмжээ тусгагдсан бөгөөд эдгээр ажил, арга хэмжээний биелэлтэд Засгийн газрын 89 дүгээр тогтоолын хавсралтын 6.2.1-д заасны дагуу үнэлгээ хийхэд 168 ажил, арга хэмжээ 100 хувийн (үр дүнтэй) үнэлгээтэй, 38 ажил 70 хувийн (тодорхой үр дүнд хүрсэн) үнэлгээтэй, 21 ажил, арга хэмжээ “үнэлэх боломжгүй” гэсэн дүнтэй гарав.

Төлөвлөгөөний биелэлтийн хувийг хүснэгтээр дор үзүүлэв.

№	Биелэлтийн дүн хувиар	Төлөвлөсөн ажлын тоо
1.	100 хувь (үр дүнтэй)	168 ажил, арга хэмжээ
2.	70 хувь (тодорхой үр дүнд хүрсэн)	38 ажил, арга хэмжээ
3.	40 (эрчимжүүлэх шаардлагатай)	0
4.	0	0
5.	Үнэлэх боломжгүй	21 ажил, арга хэмжээ
Хэрэгжилтийн хувь		94.47 хувь

Энэхүү үнэлгээний дүнд ГХЯ-ны 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт 94.47 хувьтай гарч байна.

Хавсралт: ГХЯ-ны 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг ажил, арга хэмжээ тус бүрээр үнэлсэн жагсаалт- 75 хуудас

ГХЯ-НЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР